



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/16/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2022 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn Аудитын менежер: Б.Дагвасүрэн Утас: 99014227 Цахим хаяг: dagvasurend@audit.gov.mn Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.2.1 Залруулсан алдаа	15
4.2 .2 Төлбөрийн акт	15
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТЭС СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.БАНЗРАГЧ-Д

2022.03.25 № 1302/481

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тэс сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тэс сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Төсвийн шууд захирагчийн санхүүгийн аудитаар 1 байгууллага сөрөг санал дүгнэлт авсан, ЗДТГ-ын даргын ажлын үр дүнгийн гэрээг дүгнээгүй, урамшуулал олгосон, ОНХСангийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын зориулалтыг өөрчлөхдөө сумын ИТХ-аар батлуулаагүй, иргэдээс санал авч эрэмблээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 6.4-т "Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. Үүнд: 6.4.1.Баг, хороодоос ирүүлсэн

013025580

хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх”, 6.10-т “Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулж ИТХ-д танилцуулж батлуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	599427668.51	608928571.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	55744515.14	89643515.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	55744515.14	89643515.84
3121	Төгрөг	55744515.14	89643515.84
31211	Төрийн сангийн харилцах	55724487.14	89623487.84
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	20028.00	20028.00
33	АВЛАГА	196878875.11	212887667.41
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2948008.34	73604911.64
335	Бусад авлага	193930866.77	139282755.77
3351	Байгууллагаас авах авлага	160160.00	140000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	193770706.77	139142755.77
35	БАРАА МАТЕРИАЛ	346804278.26	306397388.65
351	Түүхий эд материал	52511247.45	47084909.45
35110	Тусгай зориулалттай материал	43398185.45	39344061.01
35130	Эм боох материал	9113062.00	7740848.44
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11150020.00	11150020.00
354	Хангамжийн материал	261405510.81	230149459.20
35410	Бичиг хэргийн материал	8148040.00	8335020.00
35420	Аж ахуйн материал	34860695.00	32305160.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6359018.36	10824318.36
35440	Түлш, шатах тослох материал	5560483.10	1895469.10
35450	Барилгын засварын материал	5862700.00	3511900.00
35460	Хүнсний материал	15548630.00	8927559.00
35470	Бусад хангамжийн материал	185065944.35	164350032.74
35600	Мал амьтад	21737500.00	18013000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4985468279.10	4851737918.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4985468279.10	4851737918.68
392	Биет хөрөнгө	4874929529.10	4742736668.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	4652142626.93	4652142626.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-327907343.97	-489279065.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	238254629.00	269044629.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-153009472.51	-156779504.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	511193877.83	568375235.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-390180979.12	-427783530.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	201368301.68	180142089.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-144717458.05	-131745250.05
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	27317310.00	27412310.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	285002515.00	286002515.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-109368635.10	-124915725.00
39217	Ном	84834157.41	90120338.41
393	Биет бус хөрөнгө	110538750.00	109001250.00
39301	Програм хангамж	8902000.00	8902000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3233250.00	-4770750.00
39303	Бусад биет бус хөрөнгө	104870000.00	104870000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5584895947.61	5460666490.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20537034.07	24205253.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20537034.07	24205253.04
413	Өглөг	20537034.07	24205253.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12680398.07	52498.13
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7856636.00	24152754.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5564358913.54	5436461237.54
51	Засгийн газрын хувь оролцоо	5564358913.54	5436461237.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2737292711.33	2737292711.33
51101	Өмч: - төрийн	2737292711.33	2737292711.33
512	Хуримтлагдсан үр дүн	1349402395.65	1222726611.70
51210	Өмнөх үеийн үр дүн	1207618024.37	1350624887.70
51220	Тайлант үеийн үр дүн	141784371.28	-127897676.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1477663806.56	1476441914.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5584895947.61	5460666490.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3775632240.29	3800837142.52
11	ТАТВАРЫН ОРЛОГО	29123435.10	44562826.00
110	Орлогын албан татвар	24135935.10	12362420.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	24135935.10	12327420.00
110002	Үйл ажиллагааны орлого	23255935.10	7595420.00
110003	Хөрөнгийн орлого		3072000.00
110008	Шууд бус орлого	880000.00	1660000.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.00	35000.00
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар		35000.00
113	Хөрөнгийн албан татвар	2070000.00	26130200.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		4950700.00
113002	Бууны албан татвар	2070000.00	1822000.00
113004	Малд ногдуулах албан татвар		19357500.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2917500.00	6070206.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1157500.00	2065162.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	499500.00	1892162.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	250000.00	113000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	408000.00	60000.00
1181	Газрын төлбөр	0.00	404620.00
118101	Газрын төлбөр		404620.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1760000.00	3600424.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	1730000.00	3480424.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	30000.00	120000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	409906136.28	206180501.81
120	Нийтлэг татварын бус орлого	334487968.75	71278441.74
120002	Хүүгийн орлого	42442457.06	51630246.81
120003	Торгуулийн орлого	300000.00	436000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	291745511.69	19212194.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	291745511.69	19212194.93
121	Хөрөнгийн орлого	3176411.00	2784000.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	3176411.00	2784000.00
122	Тусламжийн орлого	72241756.53	132118060.07
122001	Хандив тусламж /дотоод/	72241756.53	132118060.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3336602668.91	3550093814.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1651927700.00	1687643400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1651927700.00	1687643400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71234222.35	169786467.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26169398.00	109136187.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45064824.35	60650280.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1586899136.56	1605478876.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	798436900.00	823470700.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	9638043.56	4992340.89
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	730932800.00	716260500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	47891393.00	60755336.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26541610.00	87185070.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	26541610.00	87185070.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3586813869.01	3831019318.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3586813869.01	3831019318.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2662375146.06	2872020106.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1627573422.76	1646302726.88
210101	Үндсэн цалин	1627573422.76	1646302726.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202889858.50	215296952.09
210201	Тэтгэврийн даатгал	138942758.50	150418213.70
210202	Тэтгэмжийн даатгал	16386752.00	16450639.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	13021458.00	13281510.91
210204	Ажилгүйдлийн даатгал	3148072.00	3671744.94
210205	Эрүүд мэндийн даатгал	31390818.00	31474843.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	381430648.58	401619884.38
210301	Гэрэл, цахилгаан	8297259.58	9630645.38
210302	Түлш, халаалт	373097389.00	391829239.00
210303	Цэвэр, бохир ус	36000.00	160000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74898829.61	160137719.86
210401	Бичиг хэрэг	13325080.00	16803040.94
210402	Тээвэр, шатахуун	37900340.06	49734473.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	6737825.55	7241054.43
210404	Ном, хэвлэл	238800.00	254800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72000.00	358500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5199390.00	31364473.25
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5101700.00	7775800.00
210408	Бараа материал акталсны зардал	6323694.00	46605578.24

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	79536394.18	105048733.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27923213.18	49405477.56
210502	Хоол, хүнс	51541581.00	55603256.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	71600.00	40000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2703650.00	9349700.00
210604	Урсгал засвар	2703650.00	9349700.00
2107	Томиллолт, зочны зардал	9285000.00	13714306.00
210702	Дотоод албан томилолт	9285000.00	13714306.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18478578.00	39386355.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15759151.00	37309340.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	955100.00	950100.00
210803	Даатгалын үйлчилгээ	289250.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	293877.00	199825.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	50600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	953400.00	203400.00
210807	Газрын төлбөр	138300.00	188290.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15700.00	15700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	265578764.43	281163728.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40071540.00	33158830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	433900.00	2112000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	225073324.43	245892898.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	924438722.95	958999211.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	60070098.00	87435786.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14263700.00	33456300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21029900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23876598.00	20739186.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	899900.00	33240300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	810305231.91	834833293.71
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	798436900.00	823470700.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9638043.56	10192340.89
213404	Хөрөнгийн	2230288.35	1170252.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	54063393.04	36730132.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	54063393.04	36730132.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	188818371.28	-30182176.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5394000.00	0.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	5394000.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	52428000.00	97715500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	594500.00	0.00
225003	Хөрөнгө оруулалтаар бэлгэгдсэн хөрөнгийн зардал		20000000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1599500.00
225007	Үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгө	51833500.00	76116000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-47034000.00	-97715500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	141784371.28	-127897676.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,737,292,711.33	1,477,663,806.56	1,210,623,172.37	0.00	5,425,579,690.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-3,005,148.00	0.00	-3,005,148.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,737,292,711.33	1,477,663,806.56	1,207,618,024.37	0.00	5,422,574,542.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	141,784,371.28	0.00	141,784,371.28
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,737,292,711.33	1,477,663,806.56	1,349,402,395.65	0.00	5,564,358,913.54
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,737,292,711.33	1,477,663,806.56	1,349,402,395.65	0.00	5,564,358,913.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,221,892.05	0.00	1,221,892.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,737,292,711.33	1,477,663,806.56	1,350,624,287.70	0.00	5,565,580,805.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	-1,221,892.05	0.00	0.00	-1,221,892.05
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-127,897,676.00	0.00	-127,897,676.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,737,292,711.33	1,476,441,914.51	1,222,726,611.70	0.00	5,436,461,237.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3415394972.07	3634407438.52
11	ТАТВАРЫН ОРЛОГО	29123435.10	44562826.00
110	Орлогын албан татвар	24135935.10	12362420.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	24135935.10	12327420.00
110002	Үйл ажиллагааны орлого	23255935.10	7595420.00
110003	Хөрөнгийн орлого		3072000.00
110008	Шууд бус орлого	880000.00	1660000.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.00	35000.00
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар		35000.00
113	Хөрөнгийн албан татвар	2070000.00	26130200.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		4950700.00
113002	Бууны албан татвар	2070000.00	1822000.00
113004	Малд ногдуулах албан татвар		19357500.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2917500.00	6070206.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1157500.00	2065162.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	499500.00	1892162.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	250000.00	113000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	408000.00	60000.00
1181	Газрын төлбөр	0.00	404620.00
118101	Газрын төлбөр		404620.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1760000.00	3600424.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	1730000.00	3480424.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	30000.00	120000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49668868.06	110478197.81
120	Нийтлэг татварын бус орлого	49668868.06	110478197.81
120002	Хүүгийн орлого	42442457.06	51630246.81
120003	Торгуулийн орлого	300000.00	436000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6926411.00	58411951.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6680000.00	55627951.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	246411.00	2784000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	3336602668.91	3479366414.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1651927700.00	1687643400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1651927700.00	1687643400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71234222.35	169786467.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26169398.00	109136187.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45064824.35	60650280.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1586899136.56	1605478876.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	798436900.00	823470700.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	9638043.56	4992340.89
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	730932800.00	716260500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	47891393.00	60755336.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26541610.00	16457670.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	26541610.00	16457670.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3340388832.35	3493601637.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3340388832.35	3493601637.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2419158809.40	2543965976.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1606108266.55	1653256108.70
210101	Үндсэн цалин	1148204780.26	1101793595.95
210102	Нэмэгдэл	342264907.29	429364247.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5544000.00	4545000.00
210104	Урамшуулал	104800179.00	112258865.00
210105	Гэрээт ажлын хөлс	5294400.00	5294400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206355485.14	220900973.51
210201	Тэтгэврийн даатгал	142273867.82	155422286.05
210202	Тэтгэмжийн даатгал	16056665.65	16898007.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	12845411.32	13079332.95
210204	Ажилгүйдлийн даатгал	3197022.12	3185401.92
210205	Эрүүд мэндийн даатгал	31982518.23	32315944.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	378655585.24	403195792.60
210301	Гэрэл, цахилгаан	8824345.58	15875995.41
210302	Түлш, халаалт	369760239.66	386089797.19
210303	Цэвэр, бохир ус	71000.00	1230000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71017396.47	75564720.27
210401	Бичиг хэрэг	11838870.00	11668820.94
210402	Тээвэр, шатахуун	43921350.92	46777644.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6651825.55	8191054.43
210404	Ном, хэвлэл	260950.00	324100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833600.00	860500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7510800.00	7742600.00

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	80577397.00	86814777.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28917442.00	31579113.00
210502	Хоол, хүнс	44184995.00	51832719.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7474960.00	3402945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3482040.00	11862900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	526400.00	1084400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	265490.00	0.00
210604	Урсгал засвар	2690150.00	10778500.00
2107	Томилолт, зочны зардал	7147049.00	13131506.00
210702	Дотоод албан томилолт	7147049.00	13131506.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22011178.00	39186055.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19333151.00	35468240.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544500.00	2616400.00
210803	Даатгалын үйлчилгээ	289250.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	293877.00	174325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	50600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1253400.00	203400.00
210807	Газрын төлбөр	162500.00	188290.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60700.00	15700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43804412.00	40053142.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36385562.00	22885645.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7418850.00	17167497.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	921230022.95	949635661.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	56861398.00	78072236.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11055000.00	25823050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21029900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23876598.00	20739186.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	899900.00	31510000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	810305231.91	834833293.71
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	798436900.00	823470700.00
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11868331.91	11362593.71
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	54063393.04	36730132.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	54063393.04	36730132.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	75006139.72	140805800.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	53069000.00	105442300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53069000.00	105442300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	53069000.00	105442300.00
223001	Бусад хөрөнгө	46880500.00	73015000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6188500.00	32427300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-53069000.00	-105442300.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1160000.00	1464500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	1160000.00	1464500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1160000.00	-1464500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20777139.72	33899000.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34967375.42	55744515.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55744515.14	89643515.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	467774400.00	483903787.00	2699246300.00	2559328797.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467774400.00	483903787.00	2553135100.00	2485849297.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467214400.00	483343787.00	2524666800.00	2458416247.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326552900.00	336984423.00	1641147600.00	1635088570.70
210101	Үндсэн цалин	218675800.00	218675800.00	1173426700.00	1100423221.95
210102	Нэмэгдэл	68607800.00	79039323.00	358343000.00	429364247.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6468000.00	6468000.00	5813000.00	4545000.00
210104	Урамшуулал	32801300.00	32801300.00	98270500.00	95461701.00
210105	Гэрээт ажлын хөлс			5294400.00	5294400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44034600.00	45026102.00	220933900.00	219373355.51
210201	Тэтгэврийн даатгал	31172500.00	32164002.00	155472100.00	153894668.05
210202	Тэтгэмжийн даатгал	3215500.00	3215500.00	16365300.00	16898007.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2572400.00	2572400.00	13092300.00	13079332.95
210204	Ажилгүйдлийн даатгал	643100.00	643100.00	3273200.00	3185401.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6431100.00	6431100.00	32731000.00	32315944.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18164200.00	20424013.27	411196300.00	403195792.60
210301	Гэрэл, цахилгаан	1962500.00	1896149.27	13205300.00	15875995.41
210302	Түлш, халаалт	15767400.00	18337864.00	394708100.00	386089797.19
210303	Цэвэр, бохир ус	434300.00	190000.00	3282900.00	1230000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23188000.00	22894450.00	76886500.00	67329619.27
210401	Бичиг хэрэг	1200000.00	1200000.00	10619500.00	10396919.94
210402	Тээвэр, шатахуун	18167000.00	17873350.00	48193000.00	43201844.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	621000.00	621000.00	8892500.00	8166054.43
210404	Ном, хэвлэл	0.00	0.00	3416900.00	438700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1200000.00	1200000.00	884400.00	860500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2000000.00	2000100.00	4880200.00	4265600.00
2105	Нормативт зардал	40562000.00	42644285.73	101010500.00	68906168.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2800000.00	30300805.73	19193600.00	14632248.00
210502	Хоол, хүнс	10062000.00	9843480.00	75292200.00	50870975.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2500000.00	2500000.00	6524700.00	3402945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3336000.00	4947560.00	6675400.00	4481900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1000000.00	981630.00	1122300.00	1084400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	483000.00	0.00
210604	Урсгал засвар	2336000.00	3965930.00	5070100.00	3397500.00
2107	Томилолт, зочны зардал	3794000.00	2052000.00	13823100.00	12762506.00
210702	Дотоод албан томилолт	3794000.00	2052000.00	13823100.00	12762506.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2582700.00	2581344.00	8267900.00	6981115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			3263300.00	3263300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700000.00	700000.00	3178800.00	2616400.00
210803	Даатгалын үйлчилгээ	200000.00	200000.00	539100.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79000.00	79000.00	295700.00	174325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25000.00	25000.00	88600.00	50600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	878700.00	878700.00	203400.00	203400.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00	188300.00	188290.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200000.00	50000.00	60700.00	15700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450000.00	598644.00	450000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000.00	5789609.00	44725600.00	40297219.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000.00	5789609.00	21156200.00	17665145.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			23569400.00	22632074.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	560000.00	560000.00	28468300.00	27433050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	560000.00	560000.00	28468300.00	27433050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			26838300.00	25823050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560000.00	560000.00	1630000.00	1610000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	96111200.00	72015000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00	96111200.00	72015000.00
223001	Бусад хөрөнгө			96111200.00	72015000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГ ДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00	50000000.00	1464500.00
230001	Эргэж төлөгдөх зээл			50000000.00	1464500.00

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	450674400.00	466255000.00	2699246300.00	2601232584.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	1694666200.00	1650913267.94
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			1694666200.00	1650913267.94
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	450674400.00	466255000.00	845235100.00	879233695.11
122005	Орон нутгийн төсвөөс	450674400.0	466255000.0	785451400.00	818478359.11
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			59783700.00	60755336.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	29698200.00	16457670.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих			29698200.00	16457670.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	129646800.00	54627951.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			37360800.00	54627951.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих			92286000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.00	23966734.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.00	65870521.60
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.0	0.0	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	0.0	0.0	6.00	6.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	133.00	133.00
620001	Удирдах ажилтан	0.0	0.0	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	0.0	0.0	91.00	91.00
620003	Үйлчлэх ажилтан	0.0	0.0	29.00	29.00
620004	Гэрээт ажилтан			1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	168616215.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	148616215.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	97977029.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	18167538.00
210101	Үндсэн цалин		1370374.00
210104	Урамшуулал	-	16,797,164.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	1527618.00
210201	Тэтгэврийн даатгал	-	1,527,618.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	8349701.00
210401	Бичиг хэрэг		1271901.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,575,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		25000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3477000.00
2105	Нормативт зардал	0.00	17908609.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	16,946,865.00
210502	Хоол, хүнс	-	961,744.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	7381000.00
210604	Урсгал засвар		7381000.00
2107	Томилголт, зочны зардал	0.00	369000.00
210702	Дотоод албан томилолт	-	369,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	32204940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		32204940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12068623.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,220,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6848123.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	50639186.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	50639186.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		20739186.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	29,900,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1170252.82
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		1170252.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	20000000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	20000000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		20000000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	169786467.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	169786467.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	109,136,187.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		60650280.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20028.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20028.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэс сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Банзрагч-д танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 01/40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжлийн төлөө ажиллахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ын үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 3,634.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 54.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75% буюу 40.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	55.7	89.6	33.9
Авлага	196.9	212.9	16.0
Бараа материал	346.8	306.4	(40.4)
Үндсэн хөрөнгө	4,985.5	4,851.7	(133.8)
Нийт хөрөнгө	5,584.9	5,460.6	(124.3)
Өр төлбөр	20.5	24.2	3.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,564.4	5,436.4	(128.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,584.9	5,460.6	(124.3)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 33.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 37.9 хувиар өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 16.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд байгууллага болон хүмүүсээс авах авлага байна.

Байгууллагаас авах авлага буюу төлбөртэй үйлчилгээ болох ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд авлага үүссэн байна.

Илрүүлэлт: ТШЗ-ын аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 54.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Бараа материал дансны үлдэгдэл 40.4 сая төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагуудын бараа материалын худалдан авалт бага байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 133.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 128.0 сая төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,776.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 77.3 сая төгрөгөөр бууруулж 2,699.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,699.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,553.1 сая төгрөгийг урсгал зардалд, 96.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 50.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,694.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 785.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 59.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 29.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 37.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 92.3 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,650.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 818.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 16.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 60.7 сая төгрөг, 54.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 2,601.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 98.0 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 50.0 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4.6 сая төгрөгийг нэмж зээлийн эргэн төлөлт хийсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,559.3 сая төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 10.2 сая төгрөгийг сумын төсөвт, 36.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 169.8 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 98.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 30.0 сая төгрөг, хөдөө ОНТША албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 20.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 20.0 сая

төгрөгийг тус тус зарцуулж 1.1 сая төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь ОНХСангийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын зориулалтыг өөрчлөхдөө сумын ИТХ-аар батлуулаагүй, иргэдээс санал авч эрэмблээгүй, хяналт тавиагүй байна. Мөн ЗДТГ-ын даргад үр дүнгийн гэрээ дүгнээгүй урамшууллыг 60 хувиар олгосон.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар Төсвийн шууд захирагчийн санхүүгийн аудитаар 1 байгууллага буюу ЗДТГазар “сөрөг” санал дүгнэлт авсан, ОНХСангийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын зориулалтыг өөрчлөхдөө сумын ИТХ-аар батлуулаагүй, иргэдээс санал авч эрэмблээгүй зөрчил байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс 121 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 25 мэдээллийг хугацаа хоцроосон, 9 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тэс сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ОНХСангийн журмын дагуу ажилласан эсэхийг нягтлан шалгах.

4. Аудитын илрүүлэлт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 0.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс зардлыг зориулалт бус зарцуулж сургуулийн ажилчдад тэмцээний хувцас 0.5 сая төгрөгөөр худалдан авсан, 0.2 сая төгрөгийг ЗДТГ-ын даргад үр дүнгийн гэрээ дүгнээгүй олгосон, урамшууллыг 60 хувиар захирамжилсан зөрчил байна.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулгын алдаа илрээгүй болно.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Зардлыг зориулалт бус зарцуулж сургуулийн ажилчдад тэмцээний хувцас худалдан авсан, ЗДТГ-ын даргад үр дүнгийн гэрээ дүгнээгүй урамшууллыг 60 хувиар олгосон зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.2. "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдээдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн алдаа зөрчлийн нэгтгэлийг доорх хүснэгтээр нэгтгэв.

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Запуулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	7	14.9			2	1.1	2	7.6	3	6.2
2	Эрүүл мэндийн төв	3	59.7			1	54.7	1	5.0	1	
3	Хүүхдийн цэцэрлэг	2	2.1			1	0.5			1	1.6
4	Соёлын төв	2	1.4			1	0.2			1	1.2
5	Ерөнхий боловсролын сургууль	2	2.2			1	0.6			1	1.6
6	ОНХС	1	52.7							1	52.7
7	ИТХ	3	7.6			1	0.1			2	7.5
8	Төвлөрүүлэн захирагч	1	0.7							1	0.7
Дүн		21	141.3	0	0	7	57.15	3	12.60	11	71.5

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2022.03.24

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.24

АХЛАХ АУДИТОР

Б.ЖАЛБАА

2022.03.24

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ

2022.03.24